

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 2-р сарын 18-ны өдөр

Дугаар 02/01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хувиарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2022 оны 2 дугаар сарын 18-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг үндэслэн Компанийн нэгж энгийн хувьцаанд 37 төгрөг 47 мөнгөний ногдол ашиг хувиарласугай.

Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022.04.15, ногдол ашиг төлөх өдрийг 2022.11.25-ны өдөр байхаар тогтоосугай.

Гурав. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Хангай), Санхүү, Эдийн засгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэсугар) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯРБААТАР